

**ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛД БАЙГУУЛЛАГУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ**

д/д	Санал ирүүлсэн байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан байдал
1.	Монгол Улсын Дээд шүүх 2024.11.25 05/5628	Танаас 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 1/1488 дугаар албан бичгээр ирүүлсэн "Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл"-д Монгол Улсын дээд шүүхийн Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимаас тусгайлсан саналгүй болохыг үүгээр уламжилъя.	Тусгайлан өгөх саналгүй.
2.	Шүүхийн ерөнхий зөвлөл 2024.11.15 03/1966	Таны 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 1/1488 дугаар албан бичгийг хүлээн авч танилцлаа. Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгуулахаар ирүүлсэн саналыг хүргүүлж байна. Үүнд: - Зөрчлийн тухай хуулийн 3.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд...” гэснийг “.....заасан эсхүл торгох шийтгэлийг баривчлах шийтгэлээр сольсон тохиолдолд” гэж өөрчлөх.	Саналыг тусгасан.
3.	Тагнуулын ерөнхий газар 2024.11.28 ТЕГ01/402	Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах саналыг тусгуулахаар хүргүүлж байна. Үүнд: 1. "Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөлд: - Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтыг "Энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэгт заасан шалгуурыг хангасан байх" гэж өөрчлөн найруулах; - Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтыг "тухайн мэдээллийг нууцад хамааруулах нь бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахааргүй мэдээлэл байх" гэж өөрчлөн найруулах; - Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг "Тухайн байгууллага албаны нууцад хамаарах мэдээллийг энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн салбарын хэмжээнд боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална" гэж өөрчлөн найруулах зэрэг болно.	Саналыг тусгасан.
4.	Монгол улсын Ерөнхий Прокурорын газар 2024.11.22 1/7521	Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж байгаатай холбогдуулан хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хавсралтаар гаргаж, саналаа дахин хүргүүлэв. Үүнд: Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: 1. Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх (10.16 дугаар зүйл) хэсгийн “3.4. хэлэлцээний явцад болон хэлэлцээ дууссанаас хойш нэг жилийн дотор аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар татан буугдсан <u>болон</u> Хөдөлмөрийн тухай хуульд зааснаас бусад...” гэх хэсэг нь бие даасан зөрчил биш үргэлжилсэн мэт уншигдаж байгаа тул “3.4. хэлэлцээний явцад болон хэлэлцээ дууссанаас хойш нэг жилийн дотор аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар татан буугдсан <u>эсхүл</u> Хөдөлмөрийн тухай хуульд зааснаас бусад...” гэж өөрчлөх. 2. Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь (5.4 дүгээр зүйл) хэсгийн “4.эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хамруулж хүнийг...” гэх хэсгийг “4.эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг....” гэж өөрчлөх. Учир нь одоо хүчин	Саналуудыг тусгасан.

		<p>төгөлдөр байгаа хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “албадан сургалтад хамруулах” албадлагын арга хэмжээг хасаж найруулсантай холбоотойгоор “хамруулж” гэснийг хасаж найруулах.</p> <p><i>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд:</i></p> <ol style="list-style-type: none"> 1. Төслийн 4 дүгээр зүйлд “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд” гэснийг “даруй зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд” гэж ... тус тус өөрчилсүгэй.” гэснийг <u>“Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэж” гэж ... тус тус өөрчилсүгэй.”</u> гэж өөрчлөх шаардлагатай. 2. Төслийн 4 дүгээр зүйл дээр <u>“Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн ...6.6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.” гэснийг “даруй зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.”</u> гэж нэмэх. 3. “Төслийн 2 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн....мөн зүйлийн 6.25 дахь залатын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “11.2,” гэж, ... тус тус нэмсүгэй.” гэсэн хэсгийг “Төслийн 2 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн....мөн зүйлийн 6.25 дахь залатын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “11.2,” гэж, <u>6.26 дахь заалтын “...Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг” гэж, ... тус тус нэмсүгэй.”</u> гэж өөрчлөх. Учир нь Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд өөрчлөлт орсон тул зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтанд шалгах зөрчлийг давхар харьяалуулах шаардлагатай. 4. Төслийн 4 дүгээр зүйлийн “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн6.8 дахь заалтын “7.6 дугаар зүйлийн” гэснийг “7.7 дугаар зүйлийн” гэж тус тус өөрчилсүгэй.” гэдгийг “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн6.8 дахь заалтын <u>“5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг,”</u> гэснийг <u>“5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг,”</u> гэж, <u>“5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь,”</u> гэснийг <u>“5.13 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг,”</u> гэж, “7.6 дугаар зүйлийн” гэснийг “7.7 дугаар зүйлийн” гэж тус тус өөрчилсүгэй.” гэж өөрчлөх. Учир нь Зөрчлийн тухай хуулийн 5.4, 5.13 дугаар зүйлүүдэд өөрчлөлт орсон боловч зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтны шалгах харьяаллыг орхигдуулсан байна. 5. Төслийн 4 дүгээр зүйллийн “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн “7.6 дугаар зүйлийн” гэснийг “7.7 дугаар зүйлийн” гэж тус тус өөрчилсүгэй.” гэснийг “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн ...8.1 дүгээр зүйлийн “7.6 дугаар зүйлийн” гэснийг “7.7 дугаар зүйлийн” гэж, <u>9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “...5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг,”</u> гэснийг <u>“... 5.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг,”</u> гэж тус тус өөрчилсүгэй.” гэж өөрчлөх. Учир нь Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2/-т 5.4 дүгээр зүйл “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” зөрчлийг өөрчлөн найруулж, мөн зүйлийн зөвхөн 5 дахь хэсэгт 	Саналуудыг тусгасан.
--	--	---	----------------------

		<p>заасан зөрчлийг тухай журам баримтлан хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахаар тусгасантай холбоотойгоор өөрчлөх шаардлагатай.</p> <p>6. Төслийн 5 дугаар зүйлийн “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн ...6.55, 6.58, 6.60 дахь заалтын “10.14, 10.29,” гэснийг, 7.3 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус хассугай.” гэснийг “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн ...6.55, 6.58, 6.60 дахь заалтын “10.14, 10.29,” гэснийг, <u>мөн зүйлийн 7 дахь хэсгийн “5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэснийг,</u> 17.3 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, <u>9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг” гэснийг</u> тус тус хассугай.” гэж өөрчлөх.</p> <p>Учир нь Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөвхөн торгох шийтгэлтэй болгож өөрчилсөнтэй холбоотойгоор зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан Эрүүгийн шүүхийн харьяалан шалгах зөрчлөөс, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээс тус тус хасах шаардлагатай.</p> <p><i>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлд оруулах тухай хуулийн төсөлд:</i></p> <p>1. Төслийн 1 дүгээр зүйлийн “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “хэвээр үйлчилнэ” гэснийг “хүчингүй болсонд тооцно.” гэж өөрчилсүгэй.” гэснийг <u>“Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</u> <u>“1 дүгээр зүйл. 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан гүйцэтгээгүй байгаа шийтгэлийг хүчингүйд тооцно.”</u>” гэж өөрчлөх. Учир нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйл 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэл хэвээр үйлчилнэ.” гэснийг бүхэлд нь хүчингүйд тооцохоор өөрчлөлт оруулсан тохиолдолд дурдсан хугацаанд оногдуулаад гүйцэтгэгдсэн бүх шийтгэлийг хүчингүй болгож, нөхөн төлөгдсөн торгуулийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд буцаан олгох ур дагавар үүсэх тул өөрчлөлтийг тодорхой заагтай тусгах шаардлагатай.</p> <p>2. Төсөлд “2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж нэмэх.</p> <p><i>Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд</i></p> <p>1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх (29.12 дугаар зүйл) хэсгийг “29.12 дугаар зүйл. Хүнийг хүчээр алга болгох</p> <p>1. Төрийн албан хаагч, төрөөс эрх олгогдсон, зөвшөөрөл авсан этгээд, эсхүл бүлэг этгээд хүнийг үндэс угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлэг, нийгмийн давхарга, бүлгийг устгах, нийгмээс тусгаарлах зорилгоор хууль бусаар саатуулсан, баривчилсан, хорьсон, хулгайлсан, хууль бусаар нууж эрх чөлөөг нь хязгаарласан, эсхүл хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан талаарх мэдээллийг нууж, мэдээлэл өгөхөөс татгалзаж эрх чөлөөг нь</p>	<p>Саналуудыг тусгасан.</p> <p>Олон улсын гэрээ конвенцын зөвлөмжид тусгасны дагуу өөрчлөн боловсруулсан тул тусгаагүй.</p>
--	--	--	---

		<p>хязгаарласны улмаас бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь хохирол, хор уршиг учруулсан нь энэ хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийн шинжгүй бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж өөрчлөх.</p> <p>Учир нь Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцийн 5 дугаар зүйлд "хүчээр алга болгох түгээмэл дэлгэрсэн буюу тогтолцоо бүхий дадлыг олон улсын одоо хэрэглэж буй эрх зүйд тодорхойлсноор хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэж үзэх бөгөөд түүний үр дагаврыг олон улсын одоо хэрэглэж буй эрх зүйн дагуу шийдвэрлэнэ" гэж заасан.</p> <p>Тус конвенци нь улс төрийн мөргөлдөөн, дайн, эрх мэдлийн дарангуйлал, дүрвэгсэдтэй холбоотой нөхцөл байдал зэргээс үүсэлтэй бөгөөд үндсэн агуулга, зохицуулалт нь энэ чиглэлд тусгагдсан, 2 дугаар зүйлд тодорхойлсон "Хүнийг хүчээр алга болгох" гэсэн тодорхойлолт нь конвенцийн бусад заалтуудтайгаа уялдаатай юм.</p> <p>Монгол Улсын Эрүүгийн хуулийн системчлэл нь тус хуулиар хамгаалагдаж буй харилцаа, халдлагын зүйлээр бүлэглэн төрөлжсөн байдаг, тухайлбал Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэгт, Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг 21 дүгээр бүлэгт, Авлига, албан тушаалтны гэмт хэргийг 22 дугаар бүлэгт гэх мэт. Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэг "Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг"-т дайн, террорист халдлага, үй олноор хөнөөх зэвсэг зэрэг хүн төрөлхтөн, улс үндэстний аюулгүй байдал, энх тайвны эсрэг үйлдэгддэг гэмт хэргийг бүлэглэн байршуулсан тул "Хүнийг хүчээр алга болгох" гэмт хэргийг тус бүлэгт байрлуулахаар бол тус бүлгийн онцлог буюу хүн төрөлхтөн, улс, үндэсний аюулгүй байдалд халдсан шинжтэй гэмт хэргийн шинжээр томъёолох нь зүйтэй юм.</p> <p>Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 29.5 дугаар зүйлд "Төрлөөр устгах" гэмт хэргийг тодорхойлсон бөгөөд түүний зарим шинж нь "Хүнийг хүчээр алга болгох" гэмт хэргийн шинжийг хангадаг буюу давхцдаг. Иймд Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцид нийцүүлэн "Хүнийг хүчээр алга болгох" гэмт хэргийг томъёолох бол "Төрлөөр устгах" гэмт хэрэгтэй нэгтгэн томъёолох. Хэрэв бие даасан гэмт хэрэг гэж үзвэл тухайн бүлгийн үндсэн шинжид хамаатуулан томъёолох шаардлагатай байна.</p> <p>Мөн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хүчээр алга болгох гэмт хэргийн субъектыг тусгай субъект байхаар зааж, 29.12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.2-т Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцийн 2 дугаар зүйлд заасан "...бүлэг этгээд" гэх ойлголтыг "зохион байгуулалттай гэмт бүлэг" гэж хүндрүүлэх шинжид заасан нь энэ гэмт хэргийн үндсэн шинжид бусад этгээд байж болох зохицуулалт орхигдсон гэж үзэхээр байна.</p> <p>Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 43 хэрэгт зохион байгуулалттай гэмт бүлэг гэх хүндрүүлэх шинжийг тусгаснаас зөвхөн Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл буюу</p>	<p>Олон улсын гэрээ конвенцын зөвлөмжид тусгасны дагуу өөрчлөн боловсруулсан тул тусгаагүй.</p>
--	--	--	---

	<p>нийтийн албан тушаалтан хахууль авах гэсэн тусгай субьекттэй гэмт хэргийн хүндрүүлэх шинжэд бас зааж өгсөн нь нийтийн албан тушаалтан зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн, эсхүл хамтран үйлдсэн тохиолдол гэж ойлгогдохоор байх тул Хүчээр алга болгох гэмт хэргийн үндсэн шинжид бусад этгээд байж болох зохицуулалтыг тусгах нь конвенцийн агуулгад нийцэхээр байна.</p> <p>2. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх (29.12 дугаар зүйл) хэсгийг “Тайлбар: -Хууль бусаар саатуулагдсан, баривчлагдсан, хоригдсон, хулгайлагдсан, эсхүл хууль бусаар нууж эрх чөлөө нь хязгаарлагдсан хүнийг сайн дураараа сулласан, суллахад хууль сахиулах байгууллагатай ажилласан, үзүүлсэн бол хариуцлагыг хамтран туслалцаа эрүүгийн хөнгөрүүлэх үндэслэл болно.” гэж өөрчлөх.</p> <p>Учир нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг сулласан, суллахад хууль сахиулах байгууллагатай хамтран ажилласан, туслалцаа үзүүлсэн бол эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх үндэслэл болох мэт ойлгогдож байх тул найруулгыг өөрчлөх.</p> <p>3. Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь (21.12 дугаар зүйл) хэсгийг “1.Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг шийтгэл хүлээлгэх, ял, оногдуулах, зорилгоор ялгаварлах айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх болон бусад хэлбэрээр өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй хэмжээний тэнцэх төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж өөрчлөх.</p> <p>Үндэслэл: НҮБ-ийн Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсын тайланд өгсөн зөвлөмжид "Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйлд заасан "Аливаа байдлаар алагчилж, эсхүл айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор эрүүдэн шүүх, мөн гуравдагч этгээдэд хамааралтай байх гэсэнтэй бүрэн нийцүүлэн тодорхойлох.</p> <p>Эрүүгийн хуулийн Хорин нэгдүгээр бүлэг "Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэгт тооцох нь конвенцын агуулгатай нийцэхгүй тул Арван гуравдугаар бүлэг "Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг"-т тооцож хуульчлах. Тус гэмт хэргийн субьектыг зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн албан хаагч, хохирогчийн хувьд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, сэрдэгдсэн этгээд байхаар явцуу хүрээнд тодорхойлсон нь учир дутагдалтай байх тул найруулгыг өөрчлөх.</p> <p>Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд</p> <p>1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх (5 дугаар зүйл. Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх) хэсгийн 1/ заалтыг:</p>	<p>Саналыг тусгаагүй.</p> <p>Хуулийн төслийн 5-д заасан агуулгад багтах тул тусгаагүй.</p>
--	---	--

		<p>“1/ яллагдагчид Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авсан өдрөөс эхлэн уг таслан сэргийлэх арга хэмжээг шүүхийн шийдвэрээр хүчингүй болгох, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох хүртэл;” гэж өөрчлөх.</p> <p><i>Үндэслэл:</i> Төслийн 1 дүгээр зүйлийн 1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 1/ дэх заалтаас үзэхэд, Монгол Улсын иргэнийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэн тохиолдол бүрт тогтоол үйлдсэн өдрөөс эхлэн түүнийг хүчингүй болгох, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох хүртэл гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх байдлаар ойлгогдохоор байна.</p> <p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйлийн 1-д "Яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах, ... хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг ...шүүх шийдвэрлэнэ." гэж, 2-т "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан таслан сэргийлэх арга хэмжээ авсан, хүчингүй болгосон тухай шүүхийн шийдвэрийг прокурор, мөрдөгч хяналт тавих байгууллагад даруй мэдэгдэнэ." гэж гагцхүү эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татагдсан хүнийг хуульд заасан тохиолдолд, тодорхой үндэслэлээр Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авах, уг таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгосон тохиолдолд шүүхийн шийдвэрийг хяналт тавих байгууллагад даруй мэдэгдэхээр хуульчилсан. Иймд дээрх зохицуулалттай уялдуулан энэ заалтын найруулгыг өөрчлөх шаардлагатай.</p> <p>2. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх (5 дугаар зүйл. Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх) хэсгийн 5/ заалтыг: “5/ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр, <u>Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авсан шүүхийн шийдвэрт заасан хугацаагаар.</u>” гэж өөрчлөх.</p> <p><i>Үндэслэл:</i> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгаж, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ." гэж хуульчилсантай нийцүүлэн найруулгыг өөрчлөх.</p> <p>3. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т бие даасан санаа бүрийг зүйлд тусгах; 28.2.3-т "...бие даасан санаа нь хэд хэдэн өгүүлбэрээр илэрхийлэгдэж байвал зүйлийг хэсэгт хуваах” гэсэн хуулийн шаардлагад нийцүүлэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь /7 дугаар зүйлийн 7.2 дахь/ хэсэгт</p>
--	--	---

		дурдсан "Итгэмжлэлийг эцэг, эх хамтран олгох бөгөөд эцэг эх нь гадаад улсад байгаа бол Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар дамжуулан итгэмжлэлийг ирүүлнэ." гэснийг тусад нь хэсэг болгон тусгах саналтай.	
5.	Цагдаагийн ерөнхий газар 2024.11.08-ны 2/382	<p>Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаад дараах саналыг тусгуулахаар хүргүүлэв. Үүнд:</p> <p>Нэг.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар</p> <p>2.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын "29.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг"-ийн "эсхүл хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан талаарх мэдээллийг нууж, мэдээлэл өгөхөөс татгалзаж эрх чөлөөг нь хязгаарласны" гэснийг хасах;</p> <p>2.2.Төслийн мөн зүйл, заалтын "29.12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1 дэх заалт"-ын "биеэ хамгаалж чадахгүй" гэснийг "биеэ хамгаалах чадваргүй" гэж өөрчлөх;</p> <p>2.3.Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын "13.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг"-ийн 2.4 дэх заалтын "биеэ хамгаалж чадахгүй" гэснийг "биеэ хамгаалах чадваргүй" гэж өөрчлөх;</p> <p>2.4.Төслийн 3 дугаар зүйлийг дор дурдсан агуулгатайгаар өөрчлөн найруулах;</p> <p>*3. Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль (Шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө."</p> <p>Хоёр.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар</p> <p>3.1.Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын "3.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг ийн "сольсон тохиолдолд" гэснийг "сольж" гэж өөрчлөх,</p> <p>3.2.Төслийн мөн зүйлийн 2 дахь заалтын "5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг"-ийн "тогтоох" гэснийг хасах, "шалгах" гэснийг "шалгаж тогтоох" гэж өөрчлөх.</p> <p>Гурав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар</p> <p>4.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын "2.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсэг"-ийн "зөрчлийн бүртгэл" гэснийг хасах;</p> <p>4.2.Төслийн мөн зүйлийн 2 дахь заалтын "7.5 дугаар зүйлийн 12 дахь хэсэг"-ийн "оногдуулах" гэснийг "оногдуулсан" гэж өөрчлөх;</p> <p>4.3.Төсөлд "Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "албадан ирүүлэх" гэснийг хасах зохицуулалт"-ыг тусгах;</p> <p>4.4.Төсөлд "Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь хэсэгт Зөрчлийн тухай хуулийн 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9 дүгээр зүйл, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг, 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.17 хэсэгт</p>	<p>1.Тусгаагүй.</p> <p>2. Тусгасан. "сольсон тохиолдолд" гэснийг хассан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу тусгасан тул саналыг тусгаагүй.</p> <p>3. Тусгах боломжгүй. Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн зохицуулалтын гол агуулга байхгүй болох тул.</p> <p>Саналын үндэслэл тодорхой тул тусгаагүй.</p> <p>4. Саналын үндэслэл тодорхой тул тусгаагүй.</p> <p>Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэсэн бие даасан үзэл баримтлалтай хуулийн төсөл тул Жагсаал,</p>

		<p>заасан зөрчлийг цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах зохицуулалт"-ыг нэмж тусгах.</p> <p>Дөрөв.Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар</p> <p>5.1.Төслийн 1 дүгээр зүйл "14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг"-ийг дор дурдсан агуулгатайгаар өөрчлөн найруулах; "14.1. Албаны нууцад хамаарах мэдээллийг жагсаалтыг боловсруулахдаа дараах шаардлагыг хангасан мэдээллийг хамааруулна:".</p> <p>5.2.Төслийн мөн зүйл "14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг"-ийн "бусад" гэснийг хасах;</p> <p>5.3.Төслийн 2 дугаар зүйлийг дор дурдсан агуулгатайгаар өөрчлөн найруулах; "2. Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль (Шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.".</p> <p>Тав.Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай</p> <p>6.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын "5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 3 дахь заалт"-ын "ял оногдуулахгүйгээр тэнссэн" гэснийг хасах;</p> <p>6.2.Төслийн мөн заалтын "5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 4 дэх заалт"-ыг хасах;</p> <p>Зургаа.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар</p> <p>7.1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын "5 дугаар зүйлийн 5.2.18 дахь заалт"-ийн "хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн байх зарчим" гэснийг "Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх, дээдлэх зарчим" гэж өөрчлөх, "хүний эрх, эрх чөлөөг зөрчөөгүй" гэсний дараа "эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж" гэж нэмэх;</p> <p>Долоо.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар</p> <p>8.1.Төслийн 1 дүгээр зүйл "55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг"-ийн "Монгол Улсын" гэсний дараа "соёрхон баталж, нэгдэн орсон" гэж нэмэх;</p> <p>8.2.Төслийн 2 дугаар зүйлийг дор дурдсан агуулгатайгаар өөрчлөн найруулах. "2. Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль (Шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.".</p>	<p>цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөлд хамааралгүй болно.</p> <p>5. Саналын үндэслэл тодорхой тул тусгаагүй.</p> <p>6.Шаардлагагүй тул тусгаагүй.</p> <p>7. Олон улсын гэрээний тухай хуульд нийцүүлэн тусгасан нэр томьёо тул тусгаагүй.</p> <p>Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт руулах тухай гэсэн бие даасан үзэл баримтлалтай хуулийн төсөл тул Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөлд хамааралгүй болно.</p>
6.	Монголын хуульчдын холбоо 2024.11.20 1/1087	<p>Танаас 2024 оны 1/1488 дугаартай албан бичгээр ирүүлсэн Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуулийн төсөлтэй танилцлаа. Тус хуулийн төсөлд хуульчдаас ирүүлсэн саналыг нэгтгэн хүргүүлж байна. Үүнд:</p> <p>1. Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотойгоор боловсруулсан Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан тус хуулийн 8 дугаар зүйлд "Өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг"-ийг бүрдүүлэх субъектэд Монголын Хуульчдын</p>	Саналуудыг тусгаагүй.

		<p>Холбоо, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо дүгнэлт гаргасан тохиолдолд хууль зүйн туслалцаа авах боломжийг бүрдүүлэх,</p> <p>2. Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотойгоор боловсруулсан Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан "өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа" гэдэгт юуг хамааруулах (журмаар тодорхойлохгүй байх) талаар зохицуулалт нэмэх;</p> <p>3. Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотойгоор боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 29.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч, төрөөс эрх олгогдсон зөвшөөрөл авсан этгээд..." гэснийг "Нийтийн албан хаагч, хуулиар эрх олгогдсон хууль сахиулагч, төрийн албан хаагч..." гэж өөрчлөх 2 дахь хэсэгт заасан "үл тоомсорлосон...." гэснийг "...хайнга хандсан" гэж өөрчлөх зэрэг болно.</p>	
7.	Монголын өмгөөлөгчдийн холбоо		Санал ирүүлээгүй.
8.	Хууль зүйн туслалцааны төв	<p><u>Хуулийн төсөлд тусгах дараах саналыг гаргаж байна. Үүнд:</u></p> <p>1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Хууль зүйн туслалцааны төвийн ажлын албыг 27 орон тоотойгоор баталсан боловч үүнээс одоогоор ажлын албанд батлагдсан орон тооны гуравны нэг орчим хувь нь нөхөгдөн ажиллаж байна. Ажлын албанд одоогоор ажиллаж буй нийт албан хаагчдын 80% нь 1 жил хүрэхгүй хугацаанд тус төвд ажиллаж байгаагаас харахад төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчим, байгууллагын бодлого, үйл ажиллагааны залгамж чанар алдагдаж байгаагаас гадна хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага хөгжиж, бэхжихэд сөргөөр нөлөөлж байна.</p> <p>Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын ажлын албаны албан хаагчдын цалин хөлсний хэмжээг улсын өмгөөлөгчийн цалин хөлстэй дүйцүүлэн, шатлалтай тогтоож, төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.</p> <p>Иймд Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-ийн "улсын өмгөөлөгчийн" гэсний дараа "болон ажлын албаны албан хаагчийн" гэж нэмэх;</p> <p>2. Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "Төрийн албаны тухай хууль" гэснийг "Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлд заасан тусламж" гэж өөрчлөх;</p> <p>3. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт "Энэ хуулийн 19.1.5-д заасан зардлыг төр хариуцна" гэснийг "Энэ хуулийн 19.1.5-д заасан улсын өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын хураамж, хуульчийн үргэлжилсэн сургалтын төлбөрийг төр хариуцна" гэж өөрчлөн найруулах;</p> <p>4. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.5 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заатыг тус тус хүчингүй болгох;</p> <p>5. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй Хууль зүйн туслалцааны тухай хуульд 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг байхад төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт эдгээр хэсгийг нэмэхээр тусгасан байгааг нягтлах;</p>	Хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэхгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.

		<p>6. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6.4 дэх хэсэг болгон шинээр нэмэхээр төсөлд тусгасан нэр томьёоны тайлбарыг холбогдох хуулиудаас харах боломжтой бөгөөд нэмэлтээр оруулах нь тухайлан ач холбогдолгүй байхын зэрэгцээ Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэгт заасан хуулийн төсөлд нэр томьёоны тайлбар хийх үндэслэлд хамаарахгүй байх тул нэр томьёоны тайлбарыг хасах;</p> <p>7. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасан журмаар зохицуулж буй харилцаа байх тул хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь энэ зүйлийн 20.1-д заасан үндэслэлээр өмгөөлөгч томилуулах тухай хүсэлтийг Өмгөөлөгчдийн Холбоонд хүргүүлнэ”, 5 дахь хэсгийн “Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь хууль зүйн туслалцаа үзүүлж ажилласан өмгөөлөгчийн үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн дүгнэлт, үр дүн, ёс зүйн болон бусад зөрчил гаргасан эсэх, шагнал урамшуулалд нэр дэвшүүлэх зэрэг асуудлаар улирал бүр холбогдох мэдээ, тайланг Өмгөөлөгчдийн Холбоонд хүргүүлнэ”, 3 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн 20.3, 20.4, 20.5 хэсгийн дугаарлалтыг 20.4, 20.5, 20,6 гэж, мөн зүйлийн 20.6 дахь хэсгийн дугаарлалтыг 20,8 гэж” гэснийг тус тус хасах саналтай байна.</p>	<p>Хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэхгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.</p>
9	Глоб Интернэшнл төрийн бус байгууллага 2024.11.25 119	Танай 2024.10.25-ны өдрийн 1/1488 тоот санал авах тухай албан бичигтэй танилцаад Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх саналгүй байна.	Тусгайлан өгөх саналгүй.
10.	Эмнести интенэшнл төрийн бус байгууллага 2024.11.19 №246	Хууль зүй дотоод хэргийн сайд таны 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 1/1488 тоот албан бичигт дурдсан Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авахаар ирүүлсэн албан бичигтэй танилцлаа. Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан өгөх саналгүй.
11.	Нээлттэй нийгэм форум	Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан өгөх саналгүй.